Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Түншлэлийн төслийн хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дашдэндэв Рэнцэнмядаг

# 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, нэгдсэн удирдлагаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх; | | | | | | | |
| 1 | Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах, төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, төслийн бүрэн шинжилгээг хянах, дүгнэх, төслийн сонгон шалгаруулалт болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | Салбар яамдаас ирүүлсэн түншлэлийн төслийн саналыг хүлээн авах, урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийлгэх ажлыг зохион байгуулж, дүгнэлтийг хянан, баталгаажуулах, сонгон шалгаруулах, шалгарсан оролцогчтой хэлэлцээр хийх, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажилласан байна /100 хувь/ | 1. Эрчим хүчний сайдаас 2025 оны а/391 дугаар албан бичгээр ирүүлсэн “Байдрагийн усан цахилгаан станц” төслийн саналыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох журам, аргачлалын дагуу хүлээн авч, тухайн төслийн урьдчилсан үнэлгээг хийлгэхээр "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-т тус яамны 2025 оны 03/419 дугаар албан бичгийг холбогдох материалын хамт хүргүүлсэн. Мөн Эрчим хүчний яам, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон холбогдох байгууллагуудаас төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багт ажиллах албан хаагчдын нэрсийг авч, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/120 дугаар тушаалаар бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулсан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-аас 2025 оны 25/61 дугаар албан бичгээр “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам төсөл”-ийн бүрэн шинжилгээ хийх хугацааг сунгах хүсэлтийг ирүүлснийг судлан, тус яамны 2025 оны 03/1420 дугаар албан бичгээр төслийн бүрэн шинжилгээ хийх хугацааг холбогдох үндэслэлээр сунгах боломжгүй талаар хариу албан бичиг хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас 2024 оны 01/2115 дугаар албан бичгээр “Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төсөл”-ийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саналыг ирүүлсэн тул Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/266 тушаалаар тус төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийг байгуулсан. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-аас 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 25/28 дугаар албан бичгээр бүрэн шинжилгээний дүгнэлт, тооцоо, судалгааг ирүүлсэн. | | |
| 2 | Түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих, түншлэлээр хэрэгжсэн төслийг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг удирдан зохион байгуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн тухай хууль болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | Түншлэлийн болон концессын гэрээнүүдийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ | 1. Тус яамны 2025 оны 03/928 дугаар албан бичгээр Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам төслийн авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт"-ийг Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас 2025.04.23-ны өдөр холбогдох зөвшөөрлийг сунгасан. 2. ЭЗХЯ-ны 2025 оны 01/1288, 01/2850 дугаар албан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

139

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бичгүүдээр “Төслийн ажлыг хэвийн явуулах боломжоор ханган, хууль тогтоомж болон концессын гэрээний хүрээнд орон нутгаас олгогдох шаардлагатай зөвшөөрлүүдийг олгон, дэмжлэг үзүүлэн ажиллах” агуулга бүхий хүсэлтийг Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Энхбатад хүргүүлсэн. 3. Концессын гэрээнд заасан барилга угсралтын ажлын хугацаа дууссан төслийн барилга угсралтын ажлын явцтай танилцах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны а/39, а/184 дүгээр тушаалаар байгуулагдаж, ажлын хэсэг төслийн талбайд 2025.11.05-2025.11.07-ны өдрүүдэд ажилласан. 2. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр зам төсөл: Концесс эзэмшигч “Монголиантранс лайн” ХХК-ийн 2025 оны 202 дугаар албан бичгээр "... төмөр замаар хил холбогдох асуудал тодорхойгүй байгаа одоогийн нөхцөлд компани санхүүгийн хувьд хэвийн үйл | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгаа тул концессын гэрээний 25.1.1-д заасан дагуу төслийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт, санхүүгийн зардал болон ирээдүйд олох ашгийг манайд олгож, төмөр замын суурь бүтцийг төрийн өмчлөлд авах" агуулга бүхий хүсэлт ирүүлснийг судлан, холбогдох хариуг хүргүүлсэн. 3. Концессын гэрээний хэрэгжилтийн явцын мэдээ, тайланг тогтмол авч, холбогдох төрийн байгууллага болон концесс эзэмшигчдэд албан бичиг хүргүүлэн, хариуг авч ажилласан . | | |
| 3 | Үр дүнтэй тогтвортой түншлэлийн орчныг бэхжүүлэх, бий болгох, түншлэлийг хөгжүүлэх, түншлэлийн төсөлтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. | Зохион байгуулах сургалтын тоо | Төр, хувийн хэвшлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | Түншлэлийг хөгжүүлэх, төслийн судалгаа, шинжилгээ хийх хүний нөөцийг чадавхжуулах, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтуудыг 3-аас доошгүй удаа зохион байгуулсан байна. /3 сургалт/ | 1. Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банк болон "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТГ-тай хамтран Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлан танилцуулах, санал солилцох "Төр, | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувийн хэвшлийн түншлэлийн форум"-ыг 2025 оны 03 дугаар сарын 13-ын өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсан. Энэхүү форумд Элчин сайдын яамд, олон улсын байгууллагууд, дотоод, гадаадын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид, олон нийтийн байгууллага болон төрийн байгууллагуудын 250 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон. 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, холбогдох журмын талаар төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн зарим албан тушаалтнуудад тогтмол мэдээллийг хуулийн хүрээнд өгч ажилласан. | | |
| 4 | Түншлэлийн хууль тогтоомж, түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийн талаарх жилийн тайланг боловсруулж, Засгийн газарт жил бүр танилцуулна. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулсан байна. /100 хувь/ | 1. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/17 дугаар тушаалаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг шинэчлэн байгуулагдаж, Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дагалдуулан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их хуралд өргөн барьсан бөгөөд Улсын Их хурлын 2025 оны 11 дүгээр сарын 14-ний нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг баталсан. 2. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-аас 2025 оны 25/65 дугаар албан бичгээр тус төслийн бүрэн шинжилгээний хүрээнд хийгдсэн тооцоо судалгаа, төслийн эх төсөл, холбогдох материалыг шинэчлэн ирүүлсний дагуу Сангийн яамнаас 2025 оны 01/6086 дугаар албан бичгээр тус төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.5-д заасны дагуу хянуулж, ЭЗХЯ-ны 2025 оны 01/1973 дугаар албан бичгээр Мөрөн-Улиастай чиглэлийн авто замын төслийг төр, хувийн хэвшүлийн түншлэлээр хэрэгжүүлэх тухай ЗГ-ын тогтоолын төсөлд бүх сайд нараас саналыг авч, ЭЗХЯ-ны 2025 оны 01/2215 дугаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн бөгөөд “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хэрэгжүүлэх тухай” Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 60 дугаар тогтоол батлагдсан. Уг ЗГ-ын тогтоолын хэрэгжилтийг хангахаар Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Зам, тээврийн сайдын хамтарсан “Ажлын хэсэг байгуулах тухай” 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/41, А/269 дугаартай тушаалаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн барих, ашиглах, шилжүүлэх гэрээний төрлөөр хэрэгжих "Мөрөн-Улиастай чиглэлийн 261.89 км авто замын төсөл"-ийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт ажиллаж байна. | | |
| 5 | Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 | Батлагдсан журам, аргачлалын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажилласан | 1. ЭЗХЯ-ны 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 08/2469 дугаартай албан бичгээр Мөрөн-Улиастай | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бичгийг боловсруулах, түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичгийг боловсруулах, төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журмыг боловсруулна. | | дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | байна. /100 хувь/ | чиглэлийн авто замын төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахтай холбогдуулан сонгон шалгаруулалтын баримт бичгийг төслийг боловсруулах тухай албан бичгийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-т хүргүүлж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн төслийг “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны 25/103 дугаар албан бичгээр хүлээн авч, санал өгч ажилласан. 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлагдсантай холбогдуулан хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор холбогдох журмуудыг шинэчлэн боловсруулах, өмнө нь Засгийн газраас батлагдан мөрдөгдөж байгаа зарим журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулах журмуудын | сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төслийг боловсруулах тухай ЭЗХЯ-ны 2025 оны 08/3115 дугаар албан бичгийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ-т хүргүүлсэн. | | |
| 6 | Нэгжийн эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хяналт тавина. | Хэрэгжилтийн явц, хувиар | Төр, хувийн хэвшлийн тухай хууль батлагдсан. 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн | Түншлэлийн төвийн үйл ажиллагааг бодлогоор зохицуулж, чиглүүлж, хяналт тавьж ажилласан байна. /100 хувь/ | 1. Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/16 дугаар тушаалаар "Түншлэлийн төсөл хөгжүүлэх сангийн бодлого, стратегийг тодорхойлох, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн тухайн жилийн төсөв, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах, сангийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус удирдах хороо"-г байгуулсан. 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төвийн үйл ажиллагаатай холбоотойгоор тус төвийн албан хаагчдыг хууль тогтоомжийн хүрээнд тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна. 3. Мөн тухай бүрт өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | түншлэлийн төвд дэмжлэг үзүүлж ажиллаж байна. | | |
| 7 | Цаг үеийн шинж чанартай, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай гүйцэтгэх. | Хэрэгжилтийн явц хувиар | Тухай бүр тайлагнасан байна. | Тухай бүр тайлагнасан байна. 100 хувь | 1. “Монголын эдийн засгийн чуулган 2025” арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх Ажлын дэд хэсгийн Нарийн бичгийн даргаар ажилласан. Чуулганы 4 үндсэн болон 12 салбар хуралдааны үндсэн агуулга, хариуцан зохион байгуулах байгууллагыг тодорхойлох, уялдааг хангах, чиглүүлэгч болон модератор, панелистаар оролцох албан тушаалтнуудыг товлох, тэмдэглэл хөтлөх үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр багийн гишүүдийн хамт амжилттай ажилласан. 2. Засгийн газрын “Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоол, тус тогтоолын 2 дугаар хавсралт “Эдийн | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийн дагуу бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор газрын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг шинэчлэн боловсруулав. 3. Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Зам, тээврийн сайдын хамтарсан "Ажлын хэсэг байгуулах тухай" 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/41, А/269 дугаар тушаалаар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн барих, ашиглах, шилжүүлэх гэрээний төрлөөр хэрэгжих "Мөрөн-Улиастай чиглэлийн 261.89 км авто замын төсөл"-ийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж байна. 4. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/216 дугаар тушаалаар | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үнэлгээг хийх ажлын хэсэгт ажиллаж байна. 5. Цаг үеийн шинжтэй , удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг шуурхай гүйцэтгэн ажиллаж байна. | | |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байх. | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байх. | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байна. 100 хувь | Хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан байна. 100 хувь | 1. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн эрх зүйн орчин болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн талаар сурталчлах, танилцуулах, санал | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | солилцож, хэлэлцэх зорилго бүхий “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн форум” -ыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан бөгөөд тус форумд гадаадын болон дотоодын хувийн хэвшил, хөрөнгө оруулагчид оролцсон. 2. Монголын эдийн засгийн форм-2025 арга хэмжээнд оролцсон. 3. Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан "Хуулийн төсөл боловсруулагчийн сургалтад 2025.08.30-31-ний өдрүүдэд хамрагдав. 4. 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан “Төсвийн зохистой удирдлагад чиглэсэн ТХХТ-ийн менежментийн чадавх бэхжүүлэх төсөл” сургалт 5. 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдсан Төрийн албанаас хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих өдөрлөгт оролцов. 6. 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцов. 7. 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр ALMEC корпорацаас зохион байгуулсан ТХХТ-ийн платформ байгуулах боломжийн талаар зөвлөлдөх уулзалт хамрагдав. | сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хавсралт: 1 файл | | |
| 2 | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх. | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байх. | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна. 100 хувь | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан байна. | Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдсан | 1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар | 100% |

ХЯНАСАН:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Төмөр Баясгалан /........................................../ Огноо: ...2025.12.12

ТАЙЛАН ГАРГАСАН:

Түншлэлийн төслийн хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Дашдэндэв Рэнцэнмядаг /........................................../
Огноо: 2025-12-12

ТУ32861 6805236 9022010236